

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Ханх сумын ТТЗ-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/016/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 88095436 Цахим хаяг:
Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг:
Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.09.25 № 01/308
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БЯМБАБАЯР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ханх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 3,873.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 1,589.2 сая төгрөгөөр буюу 69.6 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 59.1 сая төгрөгийн 4 зөрчил илэрч, орлого бүрдүүлэлт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, төрийн сангийн дотоод хяналттай холбоотой 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Ханх сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны үр дүнгийн гэрээнд 6 зорилт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, хэрэгжилтийг 89 хувьтай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		718,441.8	804,434.75
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	470,482.97	393,925.74
3	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	147,372.63	188,724.39
4	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	100,586.2	221,784.61
5	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,067,024.59	5,052,387.64
6	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	56,000	54,092
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,011,024.59	4,998,295.64
8	Биет хөрөнгө		2,944,178.59	4,918,949.64
9	Биет бус хөрөнгө	13	66,846	79,346
10	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		3,785,466.38	5,856,822.39
11	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,785,466.38	5,856,822.39
12	Засгийн газрын хувь оролцоо		3,785,466.38	5,856,822.39
13	Засгийн газрын оруулсан капитал		759,200.86	759,200.86
14	Хуримтлагдсан үр дүн		2,660,493.42	4,731,849.43
15	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		365,772.11	365,772.11
16	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,785,466.38	5,856,822.39

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,284,077.03	4,121,345.55
2	ТАТВАРЫН ОРЛОГО		620,600.46	654,754.11
3	Орлогын албан татвар		482,795.94	498,321.66
4	Хувь хүний орлогын албан татвар		482,795.94	498,321.66
5	Хөрөнгийн албан татвар		26,738.04	28,582.36
6	Бусад татвар, төлбөр, хураамж		111,066.48	127,850.09
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	551,240.1	3,466,591.44
8	Тусламжийн орлого		0	903,430.54
9	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,112,236.46	0
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,662,810.69	2,049,989.54
11	УРСГАЛ ЗАРДАЛ		1,635,860.69	1,739,963.98
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,584,718.85	1,695,076.11
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		782,120.78	913,547.55
14	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		95,759.93	111,584.48
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		203,759.27	212,642.58
16	Хангамж, бараа материалын зардал		124,845.29	62,174.16
17	Нормативт зардал		1,106	4,714
18	Эд хогшил, урсгал засварын зардал		45,017	47,014.66
19	Томилолт, зочны зардал		12,158.88	9,730
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		54,964.16	14,298.2
21	Бараа үйлчилгээний бусад зардал		264,987.56	319,370.48
22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		51,141.84	44,887.87
23	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		26,950	310,025.56
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		621,266.33	2,071,356.01
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		621,266.33	2,071,356.01

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,754,822.41	1,781,691.92
2	ТАТВАРЫН ОРЛОГО	620,600.46	654,754.11
3	Орлогын албан татвар	482,795.94	498,321.66
4	Хөрөнгийн албан татвар	26,738.04	28,582.36
5	Бусад татвар, төлбөр, хураамж	111,066.48	127,850.09
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	8,877.84	8,424.13
7	Газрын төлбөр	34,550.88	43,862.74
8	Байгалийн нөөц ашигласны төлбөр	67,637.76	75,563.23
9	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,232.91	1,126,937.81
10	Нийтлэг татварын бус орлого	39,232.91	38,107.88
11	Тусламжийн орлого	0	903,990.93
12	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	184,839
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,094,989.03	0
14	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,369,633.5	1,478,223.59
15	УРСГАЛ ЗАРДАЛ	1,369,633.5	1,478,223.59
16	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,318,491.66	1,433,335.71
17	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	781,588.42	892,711.54
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,314.9	132,335.1
19	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,617.62	226,577.25
20	Хангамж, бараа материалын зардал	70,952.49	63,661.16
21	Нормативт зардал	1,106	4,014
22	Эд хогшил, урсгал засварын зардал	51,110.4	56,064.96
23	Томилолт, зочны зардал	12,158.88	9,730
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,983.21	15,221.2
25	Бараа үйлчилгээний бусад зардал	49,659.75	33,020.5
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,141.84	44,887.87
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	385,188.91	303,468.33
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	185,466.25	310,025.56
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	185,466.25	310,025.56
30	Дотоод эх үүсвэрээр	185,466.25	310,025.56
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-185,466.25	-310,025.56
32	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	70,000
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-70,000
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	199,722.66	-76,557.23
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	270,760.31	470,482.97
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	470,482.97	393,925.74

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,204,213.89		3,204,213.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-40,013.84		-40,013.84
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,164,200.05		3,164,200.05
4	Тайлант үеийн үр дүн	621,266.33		621,266.33
5	оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,785,466.38		3,785,466.38
6	оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,785,466.38		3,785,466.38
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,785,466.38		3,785,466.38
8	Тайлант үеийн үр дүн	2,071,356.01		2,071,356.01

9	оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31- наарх үлдэгдэл	5,856,822.39	5,856,822.39
---	--	--------------	--------------

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,058,614.2	1,856,249.1	202,365.1	90.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,551,818.5	1,476,223.6	75,594.9	95.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,504,447.3	1,431,335.7	73,111.6	95.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	898,274.1	892,711.5	5,562.6	99.4
210101	Үндсэн цалин	471,301.8	465,113.6	6,188.2	98.7
210102	Нэмэгдэл	396,204.9	399,282.9	(3,078.0)	100.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,470.0	5,470.0	-	100.0
210104	Урамшуулал	25,297.4	22,845.1	2,452.3	90.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,840.8	132,335.1	1,505.7	98.9
210201	Тэтгэврийн даатгал	97,904.2	96,822.8	1,081.4	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	8,984.1	8,877.4	106.7	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,492.1	4,439.5	52.6	98.8
210204	Ажилгүйдлийн даатгал	4,492.1	4,439.5	52.6	98.8
210205	Эрүүл мэндийн даатгал	17,968.3	17,755.9	212.4	98.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	250,986.3	226,577.3	24,409.0	90.3
210301	Гэрэл, цахилгаан	41,262.4	30,353.4	10,909.0	73.6
210302	Түлш, халаалт	202,800.0	189,300.0	13,500.0	93.3
210303	Цэвэр, бохир ус	6,923.9	6,923.8	0.1	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	82,557.3	63,661.2	18,896.1	77.1
210401	Бичиг хэрэг	29,550.0	18,435.2	11,114.8	62.4
210402	Тээвэр, шатахуун	34,844.0	29,927.7	4,916.3	85.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,700.0	3,535.0	165.0	95.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,463.3	11,763.3	2,700.0	81.3
2105	Нормативт зардал	4,014.0	4,014.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,014.0	4,014.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,448.2	56,065.0	7,383.2	88.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,300.0	-	7,300.0	-
210604	Урсгал засвар	56,148.2	56,065.0	83.2	99.9
2107	Томилолт, зочны зардал	12,240.0	9,730.0	2,510.0	79.5
210702	Дотоод албан томилолт	12,240.0	9,730.0	2,510.0	79.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,468.7	15,221.2	9,247.5	62.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,743.5	12,132.2	6,611.3	64.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,152.0	-	1,152.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	165.0	-	165.0	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120.0	-	120.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88.2	-	88.2	-

Хөвсгөл аймгийн Ханх сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,200.0	2,089.0	1,111.0	65.3
210807	Газрын төлбөр	1,000.0	1,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,617.9	31,020.5	3,597.4	89.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,587.9	18,970.5	617.4	96.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,030.0	12,050.0	2,980.0	80.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,371.2	44,887.9	2,483.3	94.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,371.2	44,887.9	2,483.3	94.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,871.2	40,676.7	194.5	99.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500.0	4,211.2	2,288.8	64.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	436,795.7	310,025.6	126,770.1	71.0
223001	Бусад хөрөнгө	436,795.7	310,025.6	126,770.1	71.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,000.0	70,000.0	-	100.0
230001	Эргэж төлөгдөх зээл	70,000.0	70,000.0	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,058,614.2	1,705,600.0	(353,014.2)	82.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	188,700.0	184,900.0	(3,800.0)	98.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	188,700.0	184,900.0	(3,800.0)	98.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,869,900.0	1,520,700.0	(349,200.0)	81.3
320001	Орон нутгийн төсвөөс	1,370,600.0	1,292,400.0	(78,200.0)	94.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	71,800.0	34,700.0	(37,100.0)	48.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.0	32,900.0	(37,100.0)	47.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,800.0	1,800.0	-	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	427,500.0	193,600.0	(233,900.0)	45.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		288,200.0	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		137,600.0	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	2.0	2.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.0	25.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	4.0	4.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.0	16.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5.0	5.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.0	25.0	-	100.0
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.0	10.0	-	100.0
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.0	8.0	-	100.0

650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7.0	7.0	-	100.0
--------	-----------------------------	-----	-----	---	-------

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,327.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,327.3
122	Тусламжийн орлого	9,327.3
1221	Хандив тусламж /дотоод/	9,327.3
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,327.3
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,111.9
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,215.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	7,327.3
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(7,327.3)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(7,327.3)

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 сан, 1 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудтай холбоотой зөрчил

Илрүүлэлт: Ханх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 2,038.2 сая төгрөгийн алдаа илрүүлэн аудитын явцад бүрэн залруулж, нийт 808.1 сая төгрөгийн 8 зөрчил илрүүлж, 73.5 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж, санхүүгийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, шилэн данстай холбоотой 2 зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, хөрөнгийн тооллого хийгээгүй болон ОНХС-ийн худалдан авах ажиллагаатай холбоотой 2 зөрчилд зөрчил таслан зогсоох 1 албан шаардлагыг хүргүүлсэн.

Өгсөн зөвлөмж: Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой зөрчил

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 59.1 сая төгрөгийн 4 зөрчил илэрч, орлого бүрдүүлэлт, шилэн дансны хуулийн хэрэгжилт, төрийн сангийн дотоод хяналттай холбоотой 3 зөвлөмж, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Ханх сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс хэтрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн болно.

5.1 Албан шаардлага

Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:" гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 22.8 сая төгрөг буюу 70.6 хувиар дутуу биелүүлсэн, орон нутгийн төсвийн орлогоос 4 нэр төрлийн 36.3 сая төгрөгийн дараах орлогууд тасарсан байна. Үүнд:

- Хөрөнгийн орлого 31.1 сая төгрөг,
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.5 сая төгрөг,
- Газрын төлбөр 2.5 сая төгрөг,
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал:

Аудитын илрүүлэлт: Төрийн сангийн дотоод хяналтыг санхүү албаны дарга төсөв төрийн сангийн мэргэжилтэнгүй учраас хавсран хэрэгжүүлж байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасанд нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн мэргэжилтний сул орон тоог зарлаж, хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнаар хавсран гүйцэтгүүлэхгүй байх.

Аудитын илрүүлэлт: Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд "Худалдан авах ажиллагааны нэгтгэсэн төлөвлөгөө"-г огт мэдээлээгүй, мөн дараах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр)
- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр)
- Санхүүгийн тайлан
- Дараа жилийн төсвийн төсөл
- Худалдан авах ажиллагааны тайлан
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор" гэж заасныг тус тус зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээлэх ёстой мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлж хэвших

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Харьяа байгууллагын алдааны нэгтгэл										
СТ, тод зөрүүтэй	1	0.02			1	0.02	1	0.02		
Тайлант онд төлөгдсөн авлага бүртгээгүй	1	0.6	1	0.6			1	0.6		
Зардлын ангилал буруу бүртгэсэн	1	0.3			1	0.3	1	0.3		
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө бүртгэлд тусгаагүй	1	190.6	1	190.6			1	190.6		
Хөрөнгө илүү бүртгэсэн	1	9.8			1	9.8	1	9.8		
Хөрөнгө дутуу бүртгэсэн	1	1,832.1	1	1,832.1			1	1,832.1		
Дүн	6	2,033.4	3	2,023.3	3	10.1	6	2,033.4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн зөрчлийн нэгтгэл								
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	59.1					1	59.1
Төрийн сангийн дотоод хяналт хангалтгүй	1	-					1	-
Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй	1	-			1	-		
Дүн	3	59.1			1	-	2	59.1
Харьяа байгууллагын зөрчлийн нэгтгэл								
Дотоод хяналт хангалтгүй	1	-					1	-
Тайлангийн иж бүрдэл дутуу	1	-			1	-		
Хугацаа дууссан БМ-д арга хэмжээ аваагүй	1	4.1					1	4.1
Эдийн засаг ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан	1	20.8					1	20.8
Авлага барагдуулаагүй	1	48.7					1	48.7
Хөрөнгийн тооллого хийгээгүй	1	-			1	-		
Нийт дүн	6	73.5			2	-	4	73.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дасны тухай хуулийн хэрэгжилттэй хоолбоотой								
Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Харьяа байгууллагын зөрчлийн нэгтгэл								
Шилэн дансны мэдээллийг хагас жилээс хойш огт мэдээлээгүй	1	653.9			1	653.9		
Төсөвт өртгийг хувааж ШХА хийсэн	1	80.7			1	80.7		
Дүн	2	734.6			2	734.6		